

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
АЛТАНЦӨГЦ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/58

Цагаантунга


Газар эзэмшүүлэх эрхийн цахим дуудлага
худалдаа зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 1.2, 3.1 дэх хэсэг, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан газар эзэмших, ашиглах, эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал, Алтанцөгц сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дуудлага худалдаа явуулах зарчмаар газар эзэмших эрхийн гэрчилгээг эзэмшүүлэх 1 нэгж талбарын газрын байршил, зориулалт, хэмжээ, анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахимаар явуулах бөгөөд дуудлага худалдааг 2023 оны 06 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулсугай.

3. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг захирамж гарсан өдрөөс эхлэн 30-аас доошгүй хоног олон нийтэд ил тод мэдээллэн зарлаж дуудлага худалдааны бэлтгэл ажлыг ханган зохих хууль журмын дагуу зохион байгуулахыг Газрын даамал /Б.Кенесбек/-д үүрэг болгосугай.



Сумын Засаг даргын 2023 оны 05-р сарын
15-ны өдрийн 143-р захирамжийн хавсралт

Дуудлага худалдаа явуулах зарчмаар газар эзэмших эрхийн гэрчилгээний газрын байршил
хэмжээ зориулалт анхны үнэ дэнчингийн хэмжээ

№	Эзэмшүүлсэн газрын байршил	Газрын зориулалт	Газрын хэмжээ кв/м/га	Газрын анхны үнэ	Дэнчингийн үнэ	Эзэмшүүлэх хугацаа жил	Төлөвлөлтийн нэгж талбар
1.	Хар толгой Х.Шаривийн урд тал 4-р баг	Шатах тослох материал түгээгүүрийн газар, агуулах ШТС	1000кв/м	800,000	80,000	30	3041124

000